

# ТАНДЭМ ИНВЭСТ ББСБ ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2022 оны 01 сарын 04 өдөр

Дугаар 01

Улаанбаатар хот

## Санхүүгийн тайланд аудит хийх хөндлөнгийн аудитын байгууллага сонгох тухай

Монгол улсын компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.10 дахь заалт, Тандэм Инвэст ББСБ ХК-ийн дүрмийн 9 дүгээр зүйлийн 9.2.12.9 дахь заалтыг үндэслэн Төлөөлөн Удирдах зөвлөлөөс **ТОГТООХ** нь:

1. “Тандэм Инвэст ББСБ” ХК-ийн 2021 оны санхүүгийн тайланд хөндлөнгийн аудит хийх байгууллагаар “Шинэ их тэрбум аудит” ХХК-ийг сонгосугай.
2. “Шинэ их тэрбум аудит” ХХК-тай байгуулах гэрээний нөхцөлийг хэлэлцэн тохирох, гэрээ байгуулах, гэрээнд гарын үсэг зурах эрхийг Гүйцэтгэх захирал /Б.Золжаргал/-д олгосугай.
3. Хөндлөнгийн аудитын байгууллагыг төлөвлөсөн хугацаанд ажиллах нөхцөл боломжоор хангаж, хамтарч ажиллах, шаардлагатай мэдээлэл, баримт материалыг гаргаж өгөх, тайланг төлөвлөсөн хугацаанд нийтлэхэд шаардлагатай арга хэмжээг хэрэгжүүлж ажиллахыг Гүйцэтгэх захирал /Б.Золжаргал/-д үүрэг болгосугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА  Ч.ЧИНЗОРИГ

